

# ХУВААЛЦАХ АСУУДАЛ

Дон Хюн  
(Бодит түүхээс сэдэвлэв)

**Ш**арр, шарр, шарр. Эндрю попкорноо идчихээд, ахиад атга дүүрнийг авав.

Түүний ах Калэб буйдан дээр хажууд нь лаг хийтэл суулаа. "Хүүе, би жоохон идэж болох уу?"

Эндрю зурагтаас нүдээ салгалгүйгээр "Үгүй" гэж хариулав.

"За алив ээ. Хуваалцчих л даа" гэж ах нь хэллээ.

Калэбыг таваг руу гараа дөхүүлтэл, тэр тавгийг гял холдуулав.

"Үгүй ээ! Би чамд хэлсэн шүү дээ. Дахиж битгий гуйгаарай!"

"За, за!" гээд Калэб босон, өрөөнөөс гарав.

Маргааш нь Эндрю гал тогооны өрөө рүү орлоо.

Калэб будаа, далайн байцаа болон лаазалсан гахайн махаар сүши хийж байв.

Эндрюгийн шүлс гоожиж эхлэв. "Би жоохныг идэж болох уу?"

"Үгүй ээ" гэж Калэб хариуллаа.

Энэ нь Эндрюгийн уурыг ихэд хүргэжээ. Тэр доод давхар руу аавдаа хэлэхээр гүйлээ.

"Калэб яагаад ийм аминч байгаа юм бэ?" гэж түүнийг асуутал

аав нь хөмсөг зангидан, "Би өчигдөр чамайг попкорноо хуваалцаагүйг харсан. Чи өөрөө хуваалцаагүй атал Калэб яагаад чамтай хуваалцах ёстой гэж?" гэв.

"Яагаад гэвэл тэр чинь миний ах!" гэж Эндрю хариулжээ.

"Тэгвэл чи яагаад хуваалцаагүй юм бэ?"

"Тэр бас надтай хэзээ ч хуваалцдаггүй шүү дээ! Тэгээд ч би үүнийг өөрөө хийсэн, тэр хийгээгүй" гэж Эндрю хэлэв. Гэхдээ түүнд муухай санагдаж байлаа. Ахтайгаа хуваалцаагүй нь буруу байсан байж магадгүй.

"Солонгост хуваалцах нь маш чухал гэдгийг чи мэдэх үү?" гэж аав нь асуулаа. Эндрюгийн гэр бүл Солонгосоос ирсэн байв. "Хуваалцах нь бусдад санаа тавьдгаа харуулдаг нэг арга зам. Тэгэхээр чи хуваалцахгүй бол, энэ нь тэдэнд санаа тавьдаггүй гэж хэлж байгаатай адил байдаг."

"Гэхдээ би Калэбт санаа тавьдаг шүү дээ."

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ ХОУЛИНГ



"Хуваалцах нь хүмүүст санаа тавьдгаа харуулах нэг арга зам юм."